

## **ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлээс  
Байнгын хорооны хуралдаанд хийсэн мэдээлэл

Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ыг баталсан. Тус баримт бичигт Соёлын бодлогын зорилгыг “Соёлын үнэт зүйлийг иргэд бүтээн бий болгох, хүртэх, эзэмших, уламжлах болон соёлын өвийг найдвартай хадгалах, хамгаалах орчин нөхцөлийг бүрдүүлэх, уламжлалт соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулах, үндэсний хөгжилд соёлын эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг дээшлүүлэх, соёлын үйл ажиллагаанд иргэн, гэр бүл, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, монгол хүнийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг, соёл, уламжлалаа дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байдаг. Энэ хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлалын яам хүүхэд залуучуудад Соёлын биет болон биет бус өв, түүх, соёлын дурсгалт зүйл, соёлын илэрхийллийн олон төрлийг хадгалж хамгаалах, сурталчлан дэлгэрүүлэх, өвлөн уламжлахад хүүхэд залуучуудын оролцоог хангах, соёл урлагийн хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн байгууллагуудад хүүхдэд зориулсан орчин бий болгох, хүүхдэд зориулсан уран бүтээлийн урын санг нэмэгдүүлэх зэрэг соёл урлагийн олон талт үйл ажиллагаа явуулж байна.

2013 онд Соёл, спорт, аялал жуулчлалын яам соёлын бодлогыг соёлыг бүтээгч, идэвхтэй хүртэгч хүүхэд залуучуудыг төлөвшүүлэн хөгжүүлэх, соёлын салбарын эрх зүйн орчныг шинэчлэн боловсронгуй болгох үйл ажиллагаанд түлхүү чиглүүлж байна. Тухайлбал:

1. Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/
2. Соёл, урлагийн тухай /шинэчилсэн найруулга/
3. Номын сангийн тухай
4. Үндэсний номын сангийн эрх зүйн байдлын тухай
5. Киноны тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Эдгээр хуулийн төслүүд нь бүхэлдээ монголын ард иргэд түүн дотроо хүүхэд залуучуудын соёлын эрх, эрх чөлөөг хангах замаар монгол үндэсний соёлын өв, түүх, соёлын дурсгалын найдвартай хамгаалалт, биет болон биет бус соёлын өв хамгаалагчдыг төлөвшүүлэх, хөхиүлэн дэмжих, үндэсний соёл, урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг дээшлүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах эрх зүйн харилцааг зохицуулахад оршиж байгаа юм.

Тухайлбал Киноны тухай хуулийн төсөлд: Хүүхдэд зориулсан чанартай кино уран бүтээлийн урын санг нэмэгдүүлэх, дэлгэцэнд гаргах; хөдөө, орон нутгийн хүн амыг кино урлагаар үйлчлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар болон киног дэлгэцэнд гаргахдаа хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн байдлаар олон улсын ангиллын дагуу тусгай тэмдэг тэмдэглэгээгээр ангилж байхаар тусгаж байна

Үндэсний болон дэлхийн соёлын олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас батлан гаргасан хөтөлбөрүүд нь хүүхэд залуучуудад монгол үндэсний болон дэлхийн соёлын илэрхийллийн олон төрлийг таниулан ойлгуулах, сурталчлан дэлгэрүүлэх, хөхиүлэн дэмжих, хадгалан хамгаалах, өвлөн уламжлахад тэдний оролцоог хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгааг энд дурдах нь зүйтэй.

**2013 онд хүүхэд залуучуудыг хөгжүүлэх зорилгоор соёл, урлагийн чиглэлээр хийсэн ажлууд:**

1. “Монголын уламжлалт бий, биелгээ” хөтөлбөрийн хүрээнд Ардын язгуур урлагийн “Хөгсүү” чуулгаас зохион байгуулсан Шавь сургалтыг 23,0 сая төгрөгөөр санхүүжүүлэн дэмжив. Сургалтад нийт 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн 546 Ерөнхий боловсролын сургууль, аймгийн 185 Соёлын төв, 3 - 85 насны 15195 ардын авьяастнууд хамрагдсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд 6 дугаар сард Өвөрхангай аймгийн Арвайхээр хотноо “Бид бүжиглэх дуртай-1000” бүжгийн наадам зохион байгууллаа.

2. “Монгол тууль” хөтөлбөрийн хүрээнд Ховд аймгийн Жаргалант сумын Кульминаци ХХК-ийн Дуу, дүрс бичлэгийн Төгөлдөр студитэй гэрээ байгуулан 25,0 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлж, “Алтайн эзэд”, “Алтайн урианхайн тууль” гэсэн 2 ангит 53 минутын кино бүтээв. Энэхүү төслөөр Алтайн Урианхайн туульч Жилхэрийн удмын туульчдын намтрыг судлан бүтээсэн юм. 500 ширхэг DVD киноны нээлтийг Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

3. “Морин хуур, уртын дуу” үндэсний хөтөлбөрийн уртын дуу судлалын дотоодын шинжилгээний ангийн 2008-2010 онд гүйцэтгэсэн эх хэрэглэгдэхүүнийг “Монгол уртын дуу” аудио бичлэг бүхий ном болгон 300 хувийг 11,2 сая төгрөгөөр хэвлүүлж, номд орсон өвлөн уламжлагчид болон номын сангуудад үнэгүй хүргүүллээ.

4. “Уран манлай” ХХК-иар Увс аймгийн 19 сумын Соёлын төвд 190 ширхэг икэл хөгжим урлан бүтээж, шавь сургалт зохион байгуулахад 34,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

5. Хүүхдийн номын ордон, хүүхдийн зохиолчдын “Пен” төвтэй хамтран “Хүүхэд бүр-уншигч” аяныг орон даяар зохион байгуулав. Энэ аяны хүрээнд Архангай, Дорнод, Хөвсгөл зэрэг аймагт хүүхдийн зохиолч-уншигчдын уулзалт, “Тэргүүний уншигч хамт олон”, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын нэрэмжит Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”, “Зохиолын шилдэг дүр” шалгаруулах ажлыг зохион байгуулав.

6. Монголын балетын хөгжил сангаас зохион байгуулсан “Бидний мөрөөдөл” тоглолтод дэмжлэг үзүүлж 12,0 сая төгрөгийн санхүүжилт олголоо.

7. Засгийн газрын 2008 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Олон улсын хэмжээнд зохиогддог соёл, урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт оролцож онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох журам”-ын дагуу Бүгд Найрамдах Чех улсад болсон Я.Косианы нэрэмжит олон улсын залуу хийлчдийн уралдаанд гуравдугаар байр эзэлсэн Хөгжим, бүжгийн коллежийн сурагч П.Индрад 9.0 /есөн сая/, БНХАУ-ын Ухань хотод болсон олон улсын циркчдийн уралдаанд “Шар тогоруу хүрэл медаль” хүртсэн “Циркус Монголиа Хадгаа” циркийн уран бүтээлчдэд 34.0 /гучин дөрвөн сая/ төгрөгийн мөнгөн шагнал нийт 43.0 /дөчин гурван сая/ төгрөгийн шагнал олголоо. Мөн Франц улсад зохион байгуулагдах олон улсын мэргэжлийн төгөлдөр хуурчдын олон улсын XII уралдаанд оролцох Хөгжим бүжгийн коллежийн сурагч У.Анударийн замын зардалд Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын тушаалаар 1,886,300 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүллээ.

8. Соёл, урлагийг хөгжүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор соёл, урлагийн байгууллага, уран бүтээлчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Үүнд: “Сонгодог, урлаг-II” хөтөлбөрийн хүрээнд 2013 онд Улсын филармоний тайзнаа шинээр бүтээх “Хувдай ишигний паян” хүүхдийн симфони үлгэр, “Хөхөө Намжил” хүүхдийн бүжгэн жүжиг, “Баян Монгол мину” театрчилсан уран сэтгэмжит концертын бүтээлд 120,0 сая төгрөг, АНУ-ын Колорадо мужийн Денвер хотод 2013 оны 06 дугаар сарын 17-ноос 07 дугаар сарын 19-ний өдрүүдэд “Колорадо балетийн академи”-ийн таван долоо хоногийн зуны сургалтад оролцох Хөгжим, бүжгийн коллежийн 8 сурагч, 2 багшийн замын зардал, даатгалын зардалд шаардагдах нийт 27,1 сая төгрөгийг Соёл, урлаг хөгжүүлэх сангаас тус тус олгов.

9. Дэлхийн олон улсын музейн өдрийг тохиолдуулан Баянзүрх дүүргийн асран хамгаалагчгүй хүүхэд, сурагчдад музей үзүүлэх ажил зохион байгууллаа.

10. “Номын соёлт ертөнц” төрийн бус байгууллагатай хамтран “Номын баяр”-ыг Сүхбаатар дүүргийн Битлзийн талбайд зохион байгууллаа. 13 дахь удаагийн номын баяраар иргэдийн ном унших үйл явц, уншуулахад чиглэгдсэн уншигч-зохиолч, уншигч-номыг ойртуулах олон талт ажлууд зохион байгуулсан болно. Архангай аймагт зохион байгуулсан “Хүүхэд бүр уншигч” аянд оролцож тэргүүний уншигч, “Зохиолын шилдэг дүр”, тэргүүний уншигч-хамт олон зэргийг шалгаруулж урамшуулав.

11. Соёл, урлагийг хөгжүүлэх, уран бүтээлчдийг дэмжих, өөрийн орны иргэдэд гадаад орны соёлыг сурталчлах, гадаад харилцааг өргөтгөх зорилгоор дараах санхүүгийн дэмжлэг үзүүлээ. Үүнд: ОХУ-ын Перм хотын Бүжгийн коллежид балетийн бүжигчин мэргэжлээр суралцаж байгаа насанд хүрээгүй 12 сурагчийг хариуцан ажиллаж байгаа монгол багшийн байрны зардал, визний хураамжийг Соёл, урлаг хөгжүүлэх сангаас олгосон.

12. Хүүхдэд зориулсан уран сайхны болон хүүхэлдэйн киноны зохиол шалгаруулах” уралдааныг өнгөрсөн 7 дугаар сард олон нийтийн дунд нээлттэй зарласан билээ. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг үндэслэн зарласан энэхүү уралдаанд оролцогчдын бүтээлийг есдүгээр сарын 3-ны өдрийг хүртэл хүлээн авсан бөгөөд нийт олон ангит хүүхэлдэйн киноны зохиолын төрлөөр 15, бүрэн хэмжээний хүүхдийн уран сайхны кино зохиолын төрлөөр 26 бүтээл ирсэн юм.

Уралдаанд ирүүлэх бүтээлд хүүхдийн уран сайхны киноны зохиол нь сэдэв чөлөөтэй сургуулийн бага, дунд насныханд зориулсан нэг цагаас нэг цаг 20 минут үргэлжлэх хугацаатай байх бол олон ангит хүүхэлдэйн киноны зохиол нь бага насныханд зориулсан чөлөөт сэдэвтэй, нэг анги нь 10 минут үргэлжлэх гэсэн шаардлагыг тавиад байсан юм.

Уралдааны дүнг Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын тушаалаар томилогдсон мэргэжлийн зөвлөл уралдааны удирдамж, болзлын дагуу 3 үе шатаар шалгаруулж дүнг гаргаад байна. Уралдааны болзлын дагуу шагналт байранд шалгарсан бүтээл тус бүрт 3-5 сая төгрөгний шагнал олгогдоно.

13. 2013 оны “Номын баярын өдөр” 2013 оны 09 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд “Номын аялалд гарцгаая” уриан дор зохион болж “Үнэт ховор номын музей” ,Гахайн гурван тоорой”, “Алтан загасны үлгэр” хүүхэлдэйн кино “Номын ач тус” онол практикийн бага хурал “Тэргүүний уншигчдын өдөрлөг”, Шинэ номын сурталчилгаа нээлттэй микрофон, “Шидэт номын найзууд” зохиолын дүрийн тоглолт зэрэг арга хэмжээ зохион байгуулагдлаа.

14.Музейг хүүхэд залуучуудын хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцэхүйц түвшинд хүргэх зорилгын хүрээнд Өвөрхангай аймгийн Хархорум музейд “Уламжлалт тоглоом наадгайн хүүхдийн өрөө тохижуулах төсөл, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд “Хүүхдэд ээлтэй музей” хөтөлбөрийн хүрээнд “Цэцэрлэгийн насны хүүхдийн нас сэтгэхүй, танин мэдэхүйд түшиглэн музейг тайлбарлах нь” төслийг Соёл урлаг хөгжүүлэх сангаас санхүүжүүлж амжилттай хэрэгжүүлж дууссан.

15. Монгол Улсын хэмжээнд байгаа 8500 орчим харааны бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуучууд соёлын хүртээмжтэй үйлчилгээ хүртэж чадахгүй нийгмээс тусгаарлагдах үзэгдэл зонхилж байна. Хүн 5 мэдрэхүйн тусламжаар эргэн тойронд бүтээгдсэн бүхий л гайхамшигийг хүлээн авдаг бол харааны бэрхшээлтэй иргэд зөвхөн 20%-ийн боломжтой байдаг гэж үзэхэд тэд гарны тусламжтайгаар “тэмтэрч суралцан”, “тэмтэрч таашаан”, “тэмтэрч бишрэх” өөрөөр хэлбэл “хүрч мэдрэхүйн гайхамшиг”-г ашиглах боломжийг музей өгч чадах юм. Музейгээр дамжуулан харааны бэрхшээлтэй иргэд хүний гараар болон байгалийн гайхамшигт зүй тогтлоор бүтээгдсэн гайхамшигийг таниулах, тэдэнд зориулан байгаль эх дэлхийн бүтээлийг хүргэж, түүгээр дамжуулан үүдэж, үүдэж, үүдэж амьдралын эрч хүчийг нэмдэг. Иймээс Байгалийн Түүхийн Музей 2012-2013 харааны бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх,

соёлын хүртээмжтэй үйлчилгээ авах боломж олгох зорилготой доорх ажлуудыг зохион байгуулаад байна.

Үүнд:

Нэг.Хүрч мэдрэхүйн гайхамшиг” Музейн 1 өдрийн аялал.

Монгол Улсад анх удаа харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан “Хүрч мэдрэхүйн гайхамшиг” сэдэвтэй Музейн 1 өдрийн аялал амжилттай зохион байгуулсан.

Үр дүн ач холбогдол

Нийгмийн эмзэг бүлэг болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд соёлын хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх,

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд музейн хэрэглэгч болох боломж олгож үзмэрээр дамжуулан тэдэнд танин мэдэхүйн боловсролын ажил явуулах эхлэл болсон.

Хоёр. “Oàãààì òàÿàòàì” төсөл.

Ìíããëúí Ààéãàèèéí Ò¿¿òèéí Íóçãé, ×íéæèí Èàìúí Ñ¿ì Íóçãéí çàòèì íúãúí ¿çìúðийн хаяг тайлбарыг брайл аүүд хөрвүүлэн байрлуулах.

Үр дүн, ач холбогдол:

Байгалийн Түүхийн Музейн 1000-аад үзмэр, Чойжин Ламын Сүм Музейн 200-аад үзмэрийг брайл дээр хөрвүүлэн харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн хүртээл болгож байна.

16. Соёл, спорт, аялал жуулчлалын яамны “Палеонтологи, Археологийн Музейн Шинэчлэл” төслийн зүгээс “Үлэг гүрвэлийн дүрслэх урлаг”-ийг эх орондоо хөгжүүлэх ажлын хүрээнд 2013 оны 8 дугаар сард “Үлэг гүрвэл-Дүрслэх Урлаг” зургийн болон баримлын цуврал сургалтуудыг хүүхэд залуус, уран бүтээлчдийн дунд зохион байгуулсан. Сургалтуудыг АНУ-ын палеонтологийн уран бүтээлч Жэсон Пүүл, Дэннис Вилсон нар удирдан явуулсан бөгөөд 6 өдөр үргэлжилсэн зургийн сургалтад 25 хүн, 10 өдөр үргэлжилсэн баримлын сургалтад 20 хүн хамрагдсан юм. Сургалтад хамрагдсан уран бүтээлчид, хүүхэд залуусын бүтээлээр 11 дүгээр сарын 4-6-ны өдрүүдэд Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд үзэсгэлэн гарган олон нийтэд тайлагнасан.

17.“Тарбозавр батаарын тухай үлгэр зурж сурцгаая” номыг 5000 хувь хэвлүүлэхэд Соёл, урлаг хөгжүүлэх сангаас 5,500,000 төгрөгийн санхүүжилт олгож, 2000 ширхэг номыг “Үлэг гүрвэлийн музей”-д хүлээлгэн өгөөд байна.

18.Мөнгөн хараацай-2012 хүүхдийн урлагийн наадмын оны шилдэг шалгаруулах ёслолын ажиллагааны зардалд 10 сая төгрөг, Ерөнхий боловсролын сургуулиудын дунд 2 жил тутамд зохион байгуулагддаг Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн хөгжмийн зохиолч Ш.Гунаажавын "Манай цэргийн жавхаа" дууны нэрэмжит улсын уралдаанд дэмжлэг үзүүлэх зардалд 840 мянга, Драмын урлагийн шилдэг уран бүтээл, шилдэг уран бүтээлчийг шалгаруулах "Гэгээн муза" наадмын "Шилдэг залуу уран бүтээлч" шагналын зардалд нэг сая, Хүүхэд бүр уншигч аян зохион байгуулах зардалд 45 сая, Улаанбаатар хотноо 2013 оны 05 дугаар сарын 25-наас 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд эх үрсийн баярыг тохиолдуулан "Шинэ цирк төв"-ийн сургуультай амьтдын тоглолтыг зохион байгуулахад 8 сая төгрөг, Улсын Драмын Эрдмийн Театрт тавигдсан "Норовын намтар" хүүхэд залуучуудад зориулсан жүжгийн зардалд 58 сая 762 мянган төгрөг, Хүүхдийн зохиолч Д.Давааням "Их насны морьд", "Заан өргөсөн туулай" 2 цуврал номыг нийтийн номын санд хуваарилан олгоход 4,7 сая төгрөг, Монголын окутны холбооноос зохион байгуулсан "Цагаан уул" хайрын шүлгийн наадам зохион байгуулахад 2,2 сая төгрөг, Хүүхдэд зориулсан Наргиа хүүхдийн богино хэмжээний киноны зардалд 13 сая төгрөг, БНСУ-ын Пусан хотноо зохион байгуулах олон улсын залуучуудын чуулганд оролцох МУИС-ийн окутны замын зардалд 1 сая 929 мянган төгрөг, Хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжих зорилгоор "Царцаа Намжилын паян" бага болон дунд насны хүүхдэд зориулсан дуурь бүтээх зардалд 30 сая төгрөг, Хүүхдийн зохиолч Н.Мандалын "Зэгэл биет чалчаахай" зохиол хэвлүүлэх зардалд 5,7 сая

төгрөгийг Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас хүүхэд залуучуудыг хөгжүүлэх зорилгоор Соёл урлаг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэн хийлгэлээ.

19. Өнөөдөр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээж нар олон байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд байнгын асрамж асаргаа хэрэгтэй байдаг тул тэдгээр ээжүүд тогтмол ажил хийж чаддаггүйгээс гадна хүүхдүүдээ эм тариа авах мөнгөний хэрэгцээ байнга гардаг байна. Чингис хааны талбай дээр гаргасан Т.Батаарын үзэсгэлэнд үзэсгэлэн гаргасан гурван сарын турш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гучин ээж өөрсдийн загвараар хийсэн Т.Батаарын чихмэлийг борлуулж зургаа гаруй сая төгрөгний орлогыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүддээ зориулж чадлаа.



## 20. Монголын Үндэсний Музейн боловсрол, олон нийтийн хөтөлбөрүүд

Монголын Үндэсний музей нь 2000 оноос эхлэн албан ёсоор боловсролын ажилтны орон тоо бий болгон ажиллуулснаар музейн боловсролын ажил зохих түвшинд хөгжиж ирсэн. Олон нийтийн дунд судалгаа явуулж, тэдний насны онцлогт тохируулан олон янзын хөтөлбөрийг бий болгон, боловсролын бодлогоо баталсан. 2000 оноос гадаад дотоодын байгууллагын дэмжлэг авч музейн боловсролын олон төсөл хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлсэн. Үүнд:

2001-2003 онд Канадын сангийн ивээн тэтгэлгээр “Монголын амьд түүх” Ерөнхий боловсролын сургуулийн 8,9 дүгээр ангийн монголын түүхийн хичээл судалдаг сурагчдад зориулж боловсролын цогц төслийг хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд музейн үзмэр дээр тулгуурлан багш нарын хичээлийн хөтөлбөртэй нь уялдуулан багш нарын гарын авлага бэлтгэн гаргасан. Музейн боловсролын өрөөтэй болсон. Нүүдлийн музейн автобустай болж Хэнтий, Дорнод, Говийн 3 аймаг, Орхон, Сэлэнгэ аймгийн орон нутгийг судлах музейд боловсролын аян зохион байгуулсан байна. Гэр бүлийн тусгай билет гаргаж, музейг хямд үнээр үзэхээс гадна боловсролын өрөөнд жижиг оврын монгол гэр аав ээжийн хамт барьж үзэн, үгийн сүлжээ бөглөн, монгол үндэсний хувцас өмсөж айл

гэр болон тоглох, дурсамжит зураг даруулах Гэр бүл хөтөлбөр, Монголын уламжлалт тоглоом наадгай болох “Үйчүүр” “Хорол” “Алаг мэлхий” тоглоомын аргачлалыг судлан боловсруулж, хийлгэн, хүүхдүүдээр тоглуулж уламжлалаас суралцах. Монголын уламжлалт тоглоом наадгай бүх насныханд зориулсан хөтөлбөр, музейгээс гадагшаа чиглэсэн үйл ажиллагаа, хичээл. Музейн автобусанд хичээлийн хэрэгслээ байрлуулан сургуулиудаар нүүж очин хөтөлбөрт хамруулах “Нүүдлийн музей” соёлын өвийн боловсролын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Эдгээр хөтөлбөрүүд нь байгын тогтмол хэрэгжиж байгаа бөгөөд 2013 онд 6700 гаруй хүүхдийг боловсролын хөтөлбөрт хамруулсан байна.

### **Хөдөөгийн сум, багийн ард иргэд, хүүхэд залуучуудад төвийн мэргэжлийн соёл урлагийн байгууллагын олон нийтийг хамарсан арга хэмжээг хүргэх талаар**

Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулга, Драммын эрдмийн театр, Улсын филармони, Морин хуурын чуулга, Дуурь, бүжгийн эрдмийн театр, Хүүхэлдэйн театр зэрэг төвийн мэргэжлийн урлагийн байгууллагын шилдэг уран бүтээлээс бүрдсэн урлагийн хэсгийг алслагдсан суурин газар, сум, багт үйлчлэх төлөвлөгөө, хуваарийг боловсруулж байна. Батлагдсан хуваарийн дагуу 2013 онд 360 сая төгрөгийн төсвөөр хөдөө орон нутагт явуулын аялан тоглолт зохион байгуулж ард иргэд, хүүхэд залуучуудад төвийн мэргэжлийн соёл урлагийн байгууллагын үйлчилгээг хүргэлээ.

Өдгөө улсын хэмжээнд соёл, урлагийн 822 байгууллагад 6457 хүн ажиллаж байгаагийн дотор сумын соёлын төв 333, соёлын ордон 8, тэдгээрт 2428 хүн ажиллаж байна.

Хүн амын соёлын үйлчилгээний материаллаг баазыг сайжруулах талаар Соёл, спорт, аялал жуулчлалын яам 2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт дараах хөрөнгө оруулалт хийлээ.Үүнд:

-18 аймгийн 22 сумын Соёлын төвд нийт 189980550 төгрөгийн өртөг бүхий иж бүрэн дууны тоног төхөөрөмж

-21 аймгийн 326 сумын соёлын төвийн номын санд зураасан код уншигч принтерийн иж бүрдэл

-19 аймгийн музейд тус бүр 1 суудлын Фургон машин олгов.

Сумдын номын санд 24 нэрийн 50,0 сая төгрөгийн 3896 ширхэг номоор шинэ номын баяжилт хийлээ. Үндэсний номын сан, Хүүхдийн номын ордон, аймгийн төв номын сангаас зөөврийн номын сангийн үйлчилгээг алслагдсан нутаг дэвсгэр, байгууллагын 30 гаруй мянган уншигчдад хүргээд байна.

### **Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих талаар**

Соёл, спорт, аялал жуулчлалын яам хүүхдэд зориулсан уран бүтээлийн урын санг нэмэгдүүлэх, соёл урлагийн салбарын дэд бүтцийг сайжруулах замаар Үндэсний соёлын дархлааг бэхжүүлэх, харийн соёлын түрэлт, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан сөрөг соёлын урсгалаас хүүхэд залуучуудын оюун санааг хамгаалах арга хэмжээ авч байна.

### **Хүүхдэд зориулсан уран бүтээлийн урын санг нэмэгдүүлэх, өсвөрийн уран бүтээлчдийг дэмжих чиглэлээр:**

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Олон улсын хэмжээнд зохиогддог соёл урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт оролцож, онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн

шагнал олгох журам"-ын дагуу сүүлийн жилүүдэд Засгийн газраас 1.276.4 тэрбум төгрөгийн мөнгөн шагналыг 130 уран бүтээлчид олгосон бөгөөд үүнээс 30 шахам хувийг өсвөрийн уран бүтээлчдэд олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ын хэрэгжилтийн хүрээнд хүүхдэд зориулсан уран бүтээлийн урын санг нэмэгдүүлэх, хүүхэд залуучуудад чанартай уран бүтээл хүргэх зорилгоор энэ хугацаанд нийт 7 удаа хүүхдэд зориулсан уран бүтээлийн уралдаан зарлаж, шалгарсан уран бүтээлийг нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулж ирсэн.

2013 онд хүүхдэд зориулсан уран сайхны кино зохиол болон олон ангит хүүхэлдэйн кино зохиол шалгаруулах уралдаан зарлаж 41 бүтээл хүлээн авсан бөгөөд тэргүүн байранд шалгарсан 2 бүтээлийг дэлгэцийн бүтээл болгохоор ажиллаж байна.

Энэ 2013 онд тус яамнаас хүүхэд залуучуудыг нийгэм орчны сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зорилгоор "Мюзик Холл" Продакшны бүтээл "Цахлай нисэх гэж төрдөг" телевизийн олон ангит уран сайхны кино бүтээхэд, найруулагч УГЗ Х.Дамдины бүтээл "Наргиа" хүүхдийн богино хэмжээний хошин кино бүтээхэд, Ж.Хоролдоржийн "Шарга даага" хүүхдийн уран сайхны кино зохиолыг дэлгэцийн бүтээл туурвихад тус тус дэмжлэг үзүүлэв.

### **Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих дэд бүтцийг байгуулах чиглэлээр**

Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас "Мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагаа, орчин нөхцөлд тавигдах шаардлага"-ын төслийг боловсруулан Стандарт хэмжил зүйн газарт хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна. Мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагаа, орчин нөхцөлд тавигдах шаардлагыг боловсруулахдаа мэргэжлийн урлагийн байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдэд орчин үеийн шаардлагад нийцсэн байр танхим, үйлчилгээгээр үйлчлэхээс гадна хүүхэд, багачууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээг илүү ойртуулахад чиглэгдсэн үзүүлэлт, шаардлагуудыг тусгасан болно.

*2013 онд 11 соёл, урлагийн барилга байгууламж ашиглалтад орж, 2 барилгын зураг төсвийг бэлэн болгоод байна.*

1	<i>Соёлын төвийн барилга, 150 суудал/ Хэнтий, Дадал/</i>
2	<i>Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Баянхайрхан/</i>
3	<i>Соёл, спортын цогцолборын барилга /Өмнөговь/</i>
4	<i>Алтай чуулгын барилга, 500 суудал /Говь-Алтай/</i>
5	<i>Соёл, урлагийн заал /Дорнод, Баянтүмэн/</i>
6	<i>Соёлын төвийн барилга, 250 суудал /Увс, Наранбулаг/</i>
7	<i>Соёлын төвийн барилга, 100 суудал /Хэнтий, Баянмөнх/</i>
8	<i>Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Есөнзүйл/</i>
9	<i>Архангай Эрдэнэбулган нийтийн номын сан</i>
10	<i>Архангай Эрдэнэбулган Хүүхдийн номын ордон</i>
11	<i>Соёл, спортын төвийн барилга, 300 суудал, зуухны барилга, зам талбай /Хөвсгөл, Бүрэнтогтох/</i>
12	<i>Үндэсний номын сан, фондын барилга зураг төсөв</i>
13	<i>Соёлын өвийн төвийн барилгын зураг төсөв</i>

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 138, 206-8 -т Бүх сум, аймагт кинотеатр байгуулах, Соёл, урлагийн байгууллагыг орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах тухай

заасныг тус тус үндэслэн эхний ээлжинд дэлгэцийн тоог нэмэгдүүлэх кино үзвэрийн үндэсний сүлжээг сэргээх ажлыг эхлүүлээд байна. Үүнд:

2012-2013 онд Нийслэлийн 2 дүүргийн соёлын ордон, 18 сумын соёлын төвд жишиг кино үзвэрийн цэгийг байгуулж, орчин үеийн дуу, дүрсийн өндөр нягтралттай кино гаргалтын иж бүрэн тоног төхөөрөмж суурилуулсан нь орон нутгийн ард иргэдэд соёлын чанартай үйлчилгээ үзүүлэх, хүртээмжийг дээшлүүлэх, орчин үеийн шинэ технологитой ард иргэд, хүүхэд залуучуудыг танилцуулах, кино үзвэрийн үндэсний сүлжээг сэргээхэд бодит алхам боллоо.

Цаашид бүх сумын соёлын төвүүдэд кино үзвэрийн танхим байгуулах, орчин үеийн кино гаргалтын тоног төхөөрөмжөөр хангах, нэгдсэн сүлжээнд холбохоор төлөвлөж байна.

2014 онд Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд улс, орон нутгийн музейн сор үзмэрүүдийн тайлбарыг хүүхдэд зориулж бичүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж байна. Мөн Монгол домгийн чуулган зохион байгуулж хүүхдүүдийг үлгэр домгийн “Монгол баатар”-тай болгох ажлыг хийхээр төлөвлөж байна.

## **2. 2013 онд хүүхэд залуучуудыг хөгжүүлэх зорилгоор биеийн тамир, спортын чиглэлээр хийсэн ажлууд:**

### **Нэг. “Сургуулийн өмнөх насны хүүхдэд бие бялдрын боловсрол олгох талаар**

Сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдрыг сайжруулах ажлын хүрээнд, биеийн тамир, спорт, чийрэгжилтийн үйл ажиллагааг зохион байгуулах, бага насны хүүхдийн бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авах арга аргачлалын талаар “Сургуулийн өмнөх насны хүүхдэд бие бялдрын боловсрол олгох арга зүй” сэдэвт сургалт арга хэмжээг 2013 оны 03 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх, биеийн галбирыг хянах арга аргачиллын талаархи гарын авлага, зурагт хуудасны эхийг боловсруулж “Бага насны хүүхдийн төсөөлөн дуурайж хийх дасгалууд” ном 1000 ширхэг, Хүүхдийн биеийн галбирыг хянах арга зурагт хуудас 1000 ширхэг, Хүүхдийн биеийн галбирыг сайжруулах дасгал зурагт хуудас 1000 хувь тус тус хэвлүүлж цэцэрлэгүүдийн сургалтад зориулж олголоо.

Сургалтад Нийслэлийн хэмжээний цэцэрлэгийн эрхлэгч, багш арга зүйч нарын төлөөлөл 150 хүн оролцлоо.


**“Сургуулийн өмнөх насны хүүхдэд бие бялдрын боловсрол олгох арга зүй”** сэдэвт сургалтын хүрээнд боловсруулж хэвлүүлсэн зурагт хуудас, гарын авлага





					ҮНЭЛГЭЭ				
					A	B	C	D	F
1	3-5 нас	27076	13808	13268	1522	8808	10036	5394	1316
2	6-8 нас	26925	13177	13748	2679	8616	8055	5251	2324
3	9-11 нас	30279	14739	15540	995	3874	7471	10370	7569
4	12-17 нас	62526	31908	30618	5923	14400	20998	16194	5011
<b>НИЙТ ДҮН</b>		<b>146806</b>	<b>73632</b>	<b>73174</b>	<b>11119</b>	<b>35698</b>	<b>46560</b>	<b>37209</b>	<b>16220</b>

Судалгааны дүнгээс харахад 3-17 насны нийт хүүхдийн 32% буюу 46560 хүүхдийн үзүүлэлт С буюу дунд, 25% буюу 37209 хүүхэд D буюу дундаас доош, 11% буюу 16220 хүүхэд F буюу хангалтгүй гэсэн үзүүлэлттэй байгаа бол нийт хүүхдийн 32% нь бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшингээрээ А, В буюу хангалттай, хангалттай сайн үнэлгээ авсан байна. Өөрөөр хэлбэл БХЧТүвшин тогтоох сорилд хамрагдсан нийт хүүхдийн 68% нь бие бялдрын хөгжлийн хувьд дунд буюу дундаас доош үзүүлэлттэй байгаа нь хүүхдийн бие бялдрын боловсрол дээр анхаарах шаардлагатай байгааг анхааруулж байна.



Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан боловсролын байгууллагаар дамжуулан хүүхэд залуучуудад олгож буй биеийн тамирын хичээлийн хөтөлбөр, агуулгыг шинэчлэх, тэдэнд бие бялдрын боловсрол олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох тал дээр цаашид Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Боловсрол шинжлэх ухааны яамтай хамтран ажиллах шаардлага байгаа.

### Спортын тэмцээн, уралдааны талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 261 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсад Хүүхдийн спортын IV наадмыг 2013 оны 09 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд спортын 8 төрлөөр улсын төсвөөс 150 сая төгрөг гарган БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс болон Монгол Улсын 580 хүүхдийн дунд амжилттай зохион байгууллаа.

Мөн Засгийн газрын 2012 оны 262 дугаар тогтоолын дагуу 2013 онд Оюутны спортын III их наадмыг спортын 15 төрлөөр 2276 тамирчин, 176 дасгалжуулагч, 263 шүүгч, БНХАУ-ын Бээжин хотноо Азийн бүсийн, ОХУ-ын Москва хотноо Европын бүсийн наадамд 1400 гаруй тамирчин оюутан оролцсон арга хэмжээ болсон бөгөөд энэхүү арга хэмжээнд улсын төсвөөс 460 сая, тамирчин, дасгалжуулагчдын шагналд 202 сая төгрөгийг зарцуулсан бол ОХУ-ын Казань хотноо болсон Дэлхийн Оюутан залуучуудын 27 дахь удаагийн Зуны Универсиад наадамд түүхэнд анх удаа спортын 15 төрөлд 202

тамирчин оролцуулахад 260 сая төгрөгийг зарцуулсан. Манай оюутан тамирчид Казань хотоос гурван алт, зургаан мөнгө, 16 хүрэл, нийт 25 медальтайгаар эх орондоо ирлээ.

Ингэснээр Монголын баг тамирчид дэлхийн таван тивийн 166 орноос медалийн чанараар 20, нийт медалийн тоогоор 12 дугаар байрт бичигдсэн юм. Дэлхийн Оюутан залуучуудын спортын наадамд амжилттай оролцож медаль авсан нийт тамирчид болон тэдгээрийн дасгалжуулагч нарт Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 183 дугаар тогтоолын дагуу 201 сая төгрөгийг 2014 оны нэгдүгээр улиралд багтаан олгох юм.

Түүнчлэн ОХУ-ын Уфа хотноо зохиогдсон Олон Улсын хүүхдийн өвлийн спортын наадам, Нанжинь-2014 Өсвөр үеийнхний Зуны II Олимпийн наадамд оролцох эрх авах тэмцээн, Нанжинь-2013 Азийн хүүхдийн спортын анхдугаар наадам, Малайзын нийслэл Куала Лумпур хотноо зохиогдсон цээж бодлого, ой тогтоолтын Азийн аварга, Өсвөр үеийнхний шатрын болон даамны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зэрэг нийт 20 гаруй арга хэмжээнд Монгол Улсаа төлөөлөн оролцох тамирчин багачуудад 100 сая гаруй төгрөгийн дэмжлэг үзүүлсэн төдийгүй Оюуны бэрхшээлтэй болон саажилттай хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, биеийн тамир, спортоор дамжуулан тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч зарим ажлуудыг төлөвлөн спортын холбоодтой хамтран ажиллаж байна.

### **Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хувьд:**

#### **Нэг. Явган аялал, алхалтын зам**

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын санаачилгаар аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд явган аялал, алхалтын зам барих, тохижуулах ажлыг эхлүүлэн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусган ажилласан бөгөөд улсын хэмжээнд 16,983 км явган аялал, алхалтын замын чиглэлийг тогтоож нэгтгээд байна. Мөн ажлын хүрээнд Улаанбаатар хотноо загвар аялал, алхалтын замыг байгуулахад улсын төсвөөс 20 сая төгрөгийг гарган тохижуулсан бөгөөд нийслэлийн иргэд түүн дотороо ахмад настан, хүүхэд, залуучуудын тогтмол биеийн тамир, спортоор хичээллэх, алхах, аялах зам болсон нь амралтын өдрүүдээр өдөрт 600-800 хүн тогтмол явж хэвшсэнээс харагдаж байна.

#### **Хоёр. Усан бассейны бүхий спортын цогцолбор**

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод төв бассейн, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг, Хэнтий, Ховд, Дорноговь аймагт төрийн болон орон нутгийн өмчит усан бассейнууд үйл ажиллагаа явуулж байна. Сэлэнгэ аймгийн Мандал сум /Зүүнхараа/-д усан бассейн байгаа ч санхүүжилтгүйгээс шалтгаалан үйл ажиллагаа явуулж чадахгүй байна.

Дархан-Уул, Архангай, Сэлэнгэ аймгийн төвүүдэд өмнөх онуудад эхэлсэн усан бассейны барилгын ажил үргэлжлэн явагдаж байна.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн дагуу Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх, Сүхбаатар, Налайх дүүргийн усан бассейн бүхий спортын цогцолборын тендерийг зарласнаас Чингэлтэй, Баянзүрх дүүргийн усан бассейн бүхий спорт цогцолборыг барих гүйцэтгэгч сонгон шалгараад байна.

Аймгийн төвүүдэд барих усан бассейн бүхий спорт цогцолборын нэг загварын зургийг Эдийн засгийн хөгжлийн яамны сум төслийн хүрээнд боловсруулаад байгаа болно. Мөн Улаанбаатар хотод Спортын төв ордон шинээр барих ажлын хүрээнд 50 метрийн усан бассейн барихаар төлөвлөж байна.

Цаашид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой уялдуулсан олон талт арга хэмжээг төлөвлөж, дэс дараатай хэрэгжүүлэх болно.

Анхаарал тавьсанд баярлалаа

